



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 1/146

Номгон

Монголын бүх ард түмний спортын XV
наадмыг зохион байгуулах ажлын хэсгийг
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 17 дугаар зүйлийн 17.1, Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолоор батлагдсан “Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам-ын 2.1 дэх хэсэг, Засгийн газрын 2021 оны 268 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын бүх ард түмний спортын XV наадмын анхан шатны тэмцээнийг зохион байгуулсугай.

2. Тэмцээнийг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч Ж.Мөнхсоёл - (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд: С.Байгалмаа - (Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Д.Сарангарав - (Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Б.Наранбаяр - (Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Б.Пүрэвдагва - (Хөгжимт драмын театрын дарга)

Г.Нэмэхбаяр - (Цэргийн штабын дарга, хурандаа)

Ж.Батболд - (Тэмүжин театрын дарга)

Д.Арцад - (Биеийн тамир, спортын газрын ахлах дасгалжуулагч)

Нарийн бичгийн дарга Б.Оюунбаатар - (Биеийн тамир, спортын газрын дарга)

3. Монголын бүх ард түмний спортын XV наадмын анхан шатны тэмцээнийг орон нутагт зохион байгуулах удирдамжийг хавсралтаар баталсугай.


4. Тэмцээнд удирдамжийн дагуу орон нутгийн баг тамирчдыг бэлтгэн оролцуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

601220355

D:\2022 он\Zakhiramj-2022 он\Захирамж-2022 он+++.docx

2.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, тэмцээнийг удирдамжийн дагуу орон нутгийн хэмжээнд зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (Ж.Мөнхсоёл)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар
сарын 21-ний өдрийн А/146 дугаар
захирамжийн хавсралт

**МОНГОЛЫН БҮХ АРД ТҮМНИЙ СПОРТЫН XV НААДМЫН
АНХАН ШАТНЫ ТЭМЦЭЭНИЙ НЭГДСЭН УДИРДАМЖ**

Нэг. Зорилго

Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, 17 дугаар зүйлийн 17.1 дахь заалт, Биеийн тамир, спортын Улсын хорооны даргын 2022 оны А/17 дугаар тушаалын хэрэгжилтийг ханган иргэдийг биеийн тамир, спортын арга хэмжээ, тэмцээн, наадамд өргөнөөр хамруулах, ур чадвартай баг, тамирчдыг бэлтгэн Монголын бүх ард түмний спортын XV наадмын шигшээ тэмцээнд оролцуулахад оршино.

Хоёр. Хугацаа

2022 оны 04 дүгээр сарын 11-17-ны хооронд Баянхонгор аймагт зохион байгуулагдана.

Гурав. Хамрах хүрээ

1. Монголын бүх ард түмний спортын XV наадмын анхан шатны тэмцээнд оролцох тамирчин нь Баянхонгор аймгийн харьяат 16 нас хүрсэн иргэн байна.

2. Спортын төрөл тус бүрд Баянхонгор аймгийн 21 сумаас баг тамирчид оролцоно.

Дөрөв. Наадмын зохион байгуулалт

1. Орон нутаг дахь Монголын бүх ард түмний спортын XV наадам нь спортын 13 төрлөөр зохион байгуулагдана.

2. Орон нутагт зохион байгуулагдсан XV наадмын анхан шатны тэмцээнээс шалгарсан баг, тамирчдыг Монголын бүх ард түмний спортын XV наадмын шигшээ тэмцээнд бэлтгэн оролцуулна.

Тав. Хамтран зохион байгуулах байгууллага

1. Аймгийн Засаг даргын Тамгын газар, Нийгмийн бодлогын хэлтэс

2. Биеийн тамир спортын газар

3. Эрүүл мэндийн газар

4. Онцгой байдлын газар

5. Цагдаагийн газар

4. Спортын холбоод

9	Хөнгөн атлетик	100м, 200м, 400м, 800м, 1500м, 5000м, 4x100м /17 түүнээс дээш нас/	Цэнгэлдэх хүрээлэн	4-р сарын 15	80206100
10	Чөлөөт бөх	Эр-57кг, 65кг, 74кг, 86кг, 97кг, 125кг Эм-50кг, 53кг, 57кг, 62кг, 68кг, 76кг /18 түүнээс дээш нас/	4-р багийн спорт заал	4-р сарын 28-29	88201015
11	Жудо	Эр-60кг, 66кг, 73кг, 81кг, 90кг, -100кг, +100кг Эм-48кг, 52кг, 57кг, 63кг, 70кг, -78кг, +78кг /17 түүнээс дээш нас/	5, 6-р багийн спорт заал	4-р сарын 11-12	98111828
12	Байт харваа	Ганцаарчилсан-эр 1, эм 1 Баг тус бүр-эр 3, эм 3 тамирчин 70 метр /18 түүнээс дээш нас/	Үндэсний сурийн талбай	4-р сарын 12	89303797
13	Спорт бүжиг	/Латин 1 хос/ /Стандарт 1 хос/ /19 түүнээс дээш нас/	4-р багийн спорт заал	4-р сарын 13	88020082

Найм.Техникийн зөвлөгөөнд оролцох журам

1.Тэмцээнд оролцох сум, байгууллага, баг тамирчдын мэдүүлгийг 2022 оны 04 дүгээр сарын 04-10-ны 14.00 цаг хүртэл цахим болон цаасаар artsadsport@gmail.com хүлээн авч 04 дүгээр сарын 10-ны өдрийн 15.00 цагт Биеийн тамир, спортын газрын сургалтын танхимд техникийн зөвлөгөөнийг зохион байгуулна. /Мэдүүлгийн маягтын хавсралтыг хүргүүлэв/

2.Мэдүүлгийг тухайн сум, байгууллага, багийн Засаг даргын гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан байх ба тэмцээнд оролцох тамирчид нь вакцинд хамрагдсан нотлох баримтыг багийн мэдүүлэгт хавсаргасан байна.

3.Монголын бүх ард түмний спортын XV наадмын анхан шатны тэмцээнд оролцогч тамирчин нь төрөл тус бүрд мандатын 5000 төгрөгийг техникийн зөвлөгөөн зохион байгуулахаас өмнө мэдүүлгийн хамт төлсөн байна.

Жич: Тэмцээнд оролцох баг тамирчдын мандатын мөнгийг бүрэн тушаасан баг тамирчдыг тэмцээний сугалаанд оролцуулж, наадамд оролцох эрх үүснэ.

4.Мандатыг багуудад нэгдсэн журмаар олгох бөгөөд мандат аваагүй баг, тамирчдыг тэмцээнд оролцуулахгүй байх болно.

Ес.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын төрөл

№	Спортын төрөл	Тамирчдын тоо, жин, зай, нас	Тэмцээн болох газар	Зохион байгуулах хугацаа	Хамтран зохион байгуулах байгууллага
1	Суугаа волейбол	Эр 8 тамирчин Эм 8 тамирчин	3-р багийн спорт заал	5-р сард	Хөгжлийн бэрхшээлтэй

		/16 түүнээс дээш нас/		иргэдийн нэгдсэн төв ТББ
2	Сагсан бөмбөг	Эр 7 тамирчин Эм 7 тамирчин /16 түүнээс дээш нас/	БТСГ-ын спорт заал	
3	Хонхот бөмбөг	Эр 6 тамирчин Эм 6 тамирчин /16 түүнээс дээш нас/	3-р багийн спорт заал	
4	Ширээний теннис	Эр 1 тамирчин Эм 1 тамирчин /16 түүнээс дээш нас/	4-р багийн спорт заал	

_____оОо_____